




ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Эрчим хүч, харилцаа холбооны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД АХИЦ ГАРСАН Ч
ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГЫГ АРВИЛАН
ХЭМНЭЛТГҮЙ ЗАРЦУУЛЖ БАЙНА**

УЛААНБААТАР
2016 ОН



АГУУЛГА

Аудитыг гүйцэтгэсэн:

Гүйцэтгэлийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор
М.Наранжаргал

Аудитын менежер:
Л.Эрдэнэчулуун

Ахлах аудитор:
Б.Саруул

Ахлах шинжээч:
Б.Мөнхтуяа

Шинжээч:
Б.Анхбаатар
Б.Лхагвацэрэн

YAG-ын Гүйцэтгэлийн аудитын
газрын аудитор, шинжээчид
оролцов.

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар 261675,
261456, 263755 дугаарын утас,
323266 дугаарын факсаар
харилцана уу.

**Уг тайланг YAG-ын Веб
сайтаас үзнэ үү.**
www.audit.mn

ХАЯГ:
Үндэсний аудитын газар
Засгийн газрын IV байр,
Бага тойруу-3,
Улаанбаатар-15160
Монгол Улс
www.audit.mn

Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3
Аудитад ашигласан шалгуур	3
Товчилсон үгийн тайлбар	4
Ерөнхий мэдээлэл	5

Бүлэг 1. ХХЗХ, ЭХЗХ-ны үйл ажиллагааг зохицуулсан хуулийн зарим заалтад өөрчлөлт оруулах шаардлага бий болсон байна

- ХХЗХ, ЭХЗХ нь төрийн үйлчилгээ үзүүлсний үйлчилгээний төлбөр, хураамжаар санхүүждэг ч төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэггүй байна 7
- ЭХЗХ-ны шинэчилсэн дүрмээр ажлын албаны бүтэц, орон тоог хороо батлахаар зохицуулалт хийсэн нь хуулийн холбогдох заалттай нийцэхгүй байна 8
- ЭХЗХ үйлчилгээний цахим систем, ХХЗХ хэрэглэгчдэд үйлчлэх нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлснээр зөвшөөрөл олгоход зарцуулах хугацаа багасч хэрэглэгчдэд хүрэх мэдээлэл нээлттэй болжээ 9
- Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавих эрх зүйн шинэчлэлийг хийж, хяналтын үүргээ хэрэгжүүлж байгаа ч мэргэжлийн байгууллагаас тавих хяналт хангалтгүй байна 10
- Хуульд заасан бичиг баримтын бүрдэл хангаагүй ААН-д зөвшөөрөл олгосон тохиолдол гарсан байна 11

Бүлэг 2. Зохицуулах хороодын орлогын төвлөрүүлэлт, хөрөнгийн зарцуулалтын үр нөлөөг нэмэгдүүлэх талаар хангалтгүй ажиллаж байна

- Зохицуулалтын үйлчилгээний хөлс тооцох аргачлалыг дахин боловсруулах, төлбөр хураамжийн давхардлыг арилгах шаардлагатай байна 13
- ЭХЗХ зарим зардлыг арвилан хэмнэлтгүй зарцуулж, хөрөнгийн зарцуулалтын үр нөлөө, үр ашгийг тооцдоггүй байна 15
- ХХЗХ нь тэтгэмж, урамшууллыг хавтгайруулан олгосноос хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бий болгож байна 16

Дүгнэлт:	17
Зөвлөмж	18
ЭХЗХ-ноос ирүүлсэн санал	19
ХХЗХ-ноос ирүүлсэн санал	20
YAG-аас саналд өгсөн тайлбар	21

Монгол Улсын Ерөнхий Аудиторын тушаал	22
---	----

Аудит хийх үндэслэл**Аудитын зорилт****Аудитын хамрах хүрээ****Аудитын арга зүй****Аудитад ашигласан шалгуур****Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл**

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2016 оны 1 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/05 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон YAG-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

“Эрчим хүч, харилцаа холбооны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, үр дүн”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр гүйцэтгэв. Үүнд:

- Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа үр нөлөөтэй зохион байгуулагдсан эсэх;
- Төвлөрүүлж буй орлогын зарцуулалт үр дүнтэй эсэх;

Аудитад Эрчим хүчний зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2014-2015 оны үйл ажиллагаа, санхүүгийн баримт материал, зарим тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан.

Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 300, 3000-3100)-ийг ашиглан, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга авах, баримт материалыг түүвэрчлэн шалгах, онилсон бүлэгтэй ярилцлага хийх, ажиглалт, ажил гүйлгээний сорил хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан цуглуулсан нотлох баримтад судалгаа, харьцуулалт, дүн шинжилгээ хийж нэгтгэн аудитын дүнг боловсруулж, түүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж өглөө.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Эрчим хүчний тухай хууль;
- Харилцаа холбооны тухай хууль;
- Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль;
- Радио долгионы тухай хууль;
- Шуудангийн тухай хууль;
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль;
- Харилцаа, холбооны зохицуулах хорооны дүрэм;
- Харилцаа, холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн дүрэм;
- Эрчим хүч, харилцаа холбооны зохицуулалтын үйлчилгээний хөлс тооцох журам;
- Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох журам;
- Бусад холбогдох хууль, эрхийн актуудыг шалгуур болгон ашиглав.


ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АНЗЗ	Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл
ЗҮХ	Зохицуулалтын үйлчилгээний хөлс
МХАҮТ	Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
РДТХ	Радио долгионы тухай хууль
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТЗЭ	Тусгай зөвшөөрөл эзэмшигч
ТЗНШБ	Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлт
ТТХ	Төсвийн тухай хууль
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮЭХ	Үйлдвэрчний эвлэлийн холбоо
ХХЗХ	Харилцаа, холбооны зохицуулах хороо
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХТХ	Харилцаа холбооны тухай хууль
ХЭАХН	Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо

Ерөнхий мэдээлэл

Эрчим хүчний зохицуулах хороо (ЭХЗХ) Дэд бүтцийн сайдын харьяанд “Эрчим хүчний зохицуулах газар” нэртэй байгуулагдаж, 2011 оны Эрчим хүчний тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр хороо болон зохион байгуулагдсан. Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) Дэд бүтцийн сайдын тушаалаар “Харилцаа, холбооны зохицуулах зөвлөл” нэртэйгээр анх байгуулагдаж байсан бол Засгийн газрын 2002 оны 15 дугаар тогтоолоор Харилцаа, холбооны зохицуулах хороо болж өөрчлөгдсөн байна.

Хороодын бүтэц, зохион байгуулалт,



Эрчим хүчний зохицуулах хороо

ЭХЗХ 2014-2015 онуудад 2 алба 5 хэлтэст орон тооны 58 ажилтан, албан хаагч, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийн 21, нийт 79 ажилтантай, хүний нөөцийн хувьд тогтвортой ажиллажээ.

Тус хороо хариуцсан чиглэлээр тусгай зөвшөөрөл хүссэн ААН-үүдийн баримт бичигт үнэлгээ хийж, зөвшөөрөл олгох хүртэл үйл явцыг хариуцахаас гадна ТЗЭ-дийн тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, хэрэглэгчийн үнэ тариф, зохицуулах хороотой хийсэн гэрээний хэрэгжилт, ТЗЭ-дийн үйл ажиллагааны орлого, зардлын гүйцэтгэлд хяналт тавих чиг үүрэгтэй.

АНЗЗ нь аймаг бүрт орон тооны 1, орон тооны бус 2, нийт 63 зохицуулагчтай хуульд заасан нөхцөлөөр зөвшөөрөл олгох, орон нутгийн ТЗЭ-дийн үйл ажиллагаанд хяналт тавих, чиг үүрэгтэй ажиллаж байна.

Харилцаа, холбооны зохицуулах хороо

ХХЗХ нь 2015 оны байдлаар 5 алба, үндсэн орон тооны 74, гэрээт 20, нийт 94 ажилтан ажиллаж байна.

Тус хороо харилцаа холбооны тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт, зохицуулалт хийх, стандарт болон баталгаажуулалт хийх, дугаарлалтын үйлчилгээ эрхлэх, гомдол маргаан шийдвэрлэх зэрэг үндсэн чиглэлүүдээр үйл ажиллагаа явуулж байна.

ХХЗХ-оос радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах, харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх, контентийн үйлчилгээ эрхлэх, тоон гарын үсгийн гэрчилгээ олгох 4 төрлийн тусгай зөвшөөрлийг олгож байна.

ЭХЗХ эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах, диспетчерийн зохицуулалт хийх чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох, олгосон зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавих, үйл ажиллагааг зохицуулах, үнэ тарифыг тогтоох, эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй. Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6¹-д заасны дагуу тус хороо төсвөө бүрдүүлэн ажиллаж ирсэн бөгөөд аудитад хамрагдсан 2014-2015 оны орлого, зардлын гүйцэтгэл, орон тоог хүснэгтээр харуулбал,

Хүснэгт 1. Эрчим хүчний зохицуулах хорооны орлого, зардал, орон тооны гүйцэтгэл

Үзүүлэлт	(сая төгрөг, хүний тоо)		
	2013 он	2014 он	2015 он
Нийт орлого	1,966.3	2,150.3	2,380.8
Үндсэн үйл ажиллагааны орлого	1,961.8	2,139.7	2,375.4
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	4.5	10.6	5.4
Нийт зардал	1,334.4	2,008.2	2,300.8
Орон тоо	48	59	58
АНЗЗ-ийн орон тооны зохицуулагч	21	21	21

ЭХЗХ-ны орлого өмнөх оноос 2014 онд 9.4 хувь, 2015 онд 10.7 хувиар өсч, зардал 2014 онд 9.1 хувь, 2015 онд 11.0 хувиар тус тус өссөн байна. Харин үндсэн бус үйл ажиллагааны орлого өмнөх оны түвшингээс 2014 онд 2.3 дахин нэмэгдсэн бол 2015 онд 50.9 хувиар буурчээ.

ХХЗХ өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэн харилцаа холбооны зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, олгосон зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавих, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах, чиг үүрэгтэй байна. ХХЗХ-ны сүүлийн 3 жилийн орлого, зардал, орон тооны гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал,

Хүснэгт 2. Харилцаа, холбооны зохицуулах хорооны орлого, зардал, орон тооны гүйцэтгэл

Үзүүлэлт	(сая төгрөг, хүний тоо)		
	2013 он	2014 он	2015 он
Нийт орлого	3,994.0	6,434.1	7,711.4
Үндсэн үйл ажиллагааны орлого	3,788.0	6,068.3	6,797.7
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	206.0	365.8	913.7
Нийт зардал	3,668.6	4,706.7	4,766.4
Орон тоо: Ажлын алба	82	68	74
Гэрээт ажилтан	5	5	5
Орон нутгийн төлөөлөгч (гэрээт)	9	9	15
Нийт ажиллагсдын тоо	96	82	94

ХХЗХ-ны орлого өмнөх оноос 2014 онд 61.1 хувь, 2015 онд 19.9 хувиар өсч зардал 2014 онд 28.3 хувь, 2015 онд 1.3 хувиар тус тус өссөн байна.

Эрчим хүч, харилцаа холбооны зохицуулах хороод төсвөөс татаас, санхүүжилт авдаггүй, зохицуулалтын үйлчилгээний хөлс, радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийг тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлэн зарцуулж төсвөөс хараат бусаар үйл ажиллагаа явуулж байна.

¹ Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон болон тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлсөөр санхүүжинэ.

Бүлэг 1 ХХЗХ, ЭХЗХ-ны үйл ажиллагааг зохицуулсан хуулийн зарим заалтад өөрчлөлт оруулах шаардлага бий болсон байна

ХХЗХ, ЭХЗХ нь төрийн үйлчилгээ үзүүлсний төлбөр, хураамжаар санхүүждэг ч төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэггүй байна

1.1 ХХЗХ, ЭХЗХ нь 100 хувь төрийн өмчид үндэслэн байгуулагдсан учраас ТБОНӨТХ-ийн 13 дугаар зүйлд “Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ” гэж заасны дагуу Төрийн өмчит үйлдвэрийн газар ангилалд багтаж байна.

1.2 ЭХЗХ нь 2016 оны 1 дүгээр сараас эхлэн ТБОНӨТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2²-т заасны дагуу “аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар” статустай болсон бөгөөд ТБОНӨТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.3³-т заасны дагуу улсын төсөвт орлого төвлөрүүлэхгүй, үйл ажиллагааны үр дүнгээр шууд хуримтлагдсан ашгийг нэмэгдүүлж байгаа нь “Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар”-аар бүртгэгдсэний улмаас өөрт үлдээх ашгийн нормативт хэмжээг тогтоож өгөөгүйтэй холбоотой байна.

Хүснэгт 3.

(сая төгрөг)

Үзүүлэлт	2014 он	2015 он
Үйл ажиллагааны нийт орлого	2,150.3	2,380.8
Үйл ажиллагааны нийт зардал	1,991.6	2,292.0
Татвар төлөхийн өмнөх ашиг	158.6	88.8
Орлогын албан татварын зардал	16.6	8.9
Татварын дараах цэвэр ашиг	142.0	79.9

1.3 ХХЗХ-ны хариуцлагын хэлбэрийг 2012 онд “Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар”-аар бүртгэж, Улсын бүртгэлийн гэрчилгээ олгосон байна. Тус хороо улсын төсвөөс ямар нэг татаас, санхүүжилт авах шаардлагагүй үйл ажиллагаа явуулж байгаа нь ТБОНӨТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.3⁴-т заасан “улсын төсөвт үйлдвэрийн газар”-ын хуулийн этгээдийн тодорхойлолтой нийцэхгүй байна.

1.4 Радио долгион нь байгалийн өвөрмөц нөөц баялаг буюу РДТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1⁵-д зааснаар төрийн өмч бөгөөд ТТХ-ын 23 дугаар зүйлийн 23.11⁶-д зааснаар байгалийн баялгийн нөөцийг эзэмших, ашиглахаас бий болсон төлбөр төсвийн орлого гэж заасан. Гэтэл дээрх заалт нь ХХТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.10⁷-д ХХЗХ радио давтамж ашиглалтын төлбөрөөр санхүүжихээр заасантай уялдахгүй байна.

² Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ.

³ Үйлдвэрийн үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас эрх бүхий байгууллагаас баталсан нормативт хэмжээгээр өөртөө үлдээж захиран зарцуулах;

⁴ Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ.

⁵ Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үүсгэгчээс үүссэн болон үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд багтаж байгаа радио долгион нь Монгол Улсын төрийн өмч мөн

⁶ Газар, байгалийн баялгийн нөөцийг хуульд заасан хэлбэрээр эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдон бий болох орлого нь төсвийн орлого байна

⁷ Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлс болон радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрөөс санхүүжинэ.

1.5 ХХЗХ-ны сүүлийн 2 жилийн төсвийн гүйцэтгэлээс харахад орлого төлөвлөснөөс 2014 онд 869.6 сая, 2015 онд 483.2 сая төгрөгөөр тус тус илүү төвлөрч, мөнгөн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдэл сүүлийн 2 жил дараалан 2.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал,

Хүснэгт 4. ХХЗХ-ны төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлт (сая төгрөг)

Нэр, төрөл	2014 он		2015 он	
	Төл	Гүйц	Төл	Гүйц
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	2,242.5	2,241.5	2,606.0	2,606.8
Орлого	4,410.0	5,279.6	5,050.0	5,533.2
Зарлага	6,642.1	4,914.3	7,652.3	5,512.7
Зарцуулагдаагүй үлдэгдэл	10.4	2,606.8	3.7	2,627.3

1.6 Иймд хороодын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, эрх зүйн актад өөрчлөлт оруулах, хуулийн этгээдийн статусыг тодорхой болгох төр өмчөө эзэмшүүлэх, ашиглуулах, захиран зарцуулахтай холбоотойгоор бий болсон орлого буюу радио давтамж ашиглалтын төлбөр болон хороодын үйл ажиллагааны орлогын тодорхой хэсгийг улсын төсөвт төвлөрүүлэх боломж байна.

ЭХЗХ-ны шинэчилсэн дүрмээр ажлын албаны бүтэц, орон тоог хороо батлахаар зохицуулалт хийсэн нь хуулийн холбогдох заалттай нийцэхгүй байна

1.7 ЭХЗХ-ны хувьд Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3⁸-т хорооны дарга, орон тооны болон орон тооны бус зохицуулагчдыг Эрчим хүчний сайд, МХАҮТ, ХЭАХН-ийн саналыг үндэслэн Ерөнхий сайд томилдог бөгөөд Засгийн газрын 2012 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1⁹-д заасны дагуу ажлын албаны бүтэц, орон тоог эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн хорооны тогтоолоор баталж иржээ.

1.8 Харин Засгийн газрын 2016 оны 132 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан дүрмийн 5.1¹⁰-д ажлын албаны бүтэц, орон тооны хязгаарыг хороо батлахаар заасан нь ТБОНӨТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.5¹¹ дахь заалттай нийцэхгүй байна.

1.9 ХХЗХ-ны хувьд ХХТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.3¹²-т заасны дагуу зохицуулах хорооны дарга болон орон тооны бус 6 гишүүдийг Ерөнхий сайд томилж, дээрх хуулийн 8 дугаар зүйлийн 8.8¹³, 8.9¹⁴-д заасны дагуу тус хороо ажлын албатай, орон нутагт орон тооны бус салбар зөвлөлтэй байж болохоор байна.

⁸ Зохицуулах хорооны дарга, орон тооны хоёр зохицуулагчийг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, орон тооны бус хоёр зохицуулагчийг Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн саналыг тус тус үндэслэн Ерөнхий сайд анхны томилгоог 2, 4, 6 жилээр, цаашид 3 жилийн хугацаагаар томилно. Томилолтын хугацааг нэг удаа сунгаж болно.

⁹ Хорооны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий ажлын албаны бүтэц, орон тоог эрчим хүчний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн зохицуулах хорооны хурал тогтооно.

¹⁰ ...Ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг Хороо батална.

¹¹ Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиргааны албан тушаалын жагсаалт, орон тооны нормативыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.


¹² Зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилно.

¹³ Зохицуулах хороо нь ажлын албатай байна.

¹⁴ Зохицуулах хороо нь орон нутагт орон тооны бус гишүүдээс бүрдэх салбар зөвлөлтэй байж болно.


ЭХЗХ үйлчилгээний цахим систем, ХХЗХ хэрэглэгчдэд үйлчлэх нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлснээр зөвшөөрөл олгоход зарцуулах хугацаа багасч хэрэглэгчдэд хүрэх мэдээлэл нээлттэй болжээ

1.10 2014 оноос зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд цахим системийг үе шаттай нэвтрүүлж эхэлснээр зөвшөөрөл хүсэгч ААН-үүд хүссэн үедээ цахим системд өргөдөл, бичиг баримтаа бүртгүүлж, үйлчилгээний шат дамжлага багасч зөвшөөрөл олгох хуулийн хугацаа 60 хоног 7-10 хоногоор буурсан эерэг үзүүлэлт гарчээ. Зөвшөөрөл олгох үйл явцыг дүрслэлээр үзүүлбэл,



1.11 ЭХЗХ нь 2014-2015 онуудад эрчим хүчний барилга, байгууламж барих, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах, цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах зэрэг төрлөөр 63 ААН-д зөвшөөрөл олгосон байна. Цахилгаан, дулаан дамжуулах, хийгээр хангах чиглэлээр тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл бүртгэгдээгүй байна.

1.12 ХХЗХ нь 2015 онд “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-д өөрчлөлт оруулж, “Зөвшөөрөл олгох хүсэлт хүлээн авах, бүртгэх, үнэлгээ хийх, шийдвэрийг мэдэгдэх дотоод үйл ажиллагааны журам”-ыг шинээр батлан мөрдөж, нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлсэн нь тусгай зөвшөөрөл олгох шат дамжлагыг багасгах оновчтой, шуурхай, ил тод болгон эргэх холбоог сайжруулж, үйлчилгээний шат дамжлага буурсан байна. Хорооны тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг дүрслэлээр үзүүлбэл;



1.13 ХХЗХ-нд 2014 онд тусгай зөвшөөрөл эзэмших 225 хүсэлт ирүүлснээс 131-т, 2015 онд 152 хүсэлт ирүүлснээс 86-д тусгай зөвшөөрөл олгосноос харахад нийт ирүүлсэн хүсэлтийн дунджаар 42.4 хувь нь буцаагдсан байна.

1.14 ХХЗХ тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл хүлээн авахаас олгох хүртэлх 30 хоногийн хугацаанд судлан шийдвэрлэдэг бөгөөд 2015 оны эцсийн байдлаар давхардсан тоогоор 1,304 тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, ААНБ байна.

1.15 Зөвшөөрөл олгогдоогүй шалтгааныг судалж үзэхэд зөвшөөрөл хүсэгчийн бичиг баримтын иж бүрдэл дутуу, хүний нөөц, техник, санхүүгийн чадамж хангалтгүй зэрэг үндэслэлүүд голлож байна. 2016 оны 2 дугаар сарын байдлаар нийт 4,312 зөвшөөрөл болон эрхийн бичиг олгосноос хүчинтэй 2,378, цуцалсан 1,849, түдгэлзүүлсэн 30, хугацаа дууссан 55 зөвшөөрөл байна.

Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавих эрх зүйн шинэчлэлийг хийж, хяналтын үүргээ хэрэгжүүлж байгаа ч мэргэжлийн байгууллагаас тавих хяналт хангалтгүй байна

1.16 Эрчим хүч, харилцаа холбооны чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгохдоо зөвшөөрөл эзэмшигчидтэй нөхцөл шаардлагын биелэлтийг хангаж ажиллахыг үүрэг болгон гэрээ байгуулдаг байна.

1.17 Гэрээний дагуу ХХЗХ, ЭХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хяналт шинжилгээ, зохицуулалт, үнэлгээ хариуцсан албадууд олгосон зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавих чиг үүрэгтэй байна.

1.18 ЭХЗХ байгуулагдсанаас хойш ТЗНШБ-ийг зохицуулсан тодорхой журам, зааваргүй ажиллаж байсныг өөрчилж, 2014 онд “Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага тогтоох, үнэлэх журам”-ыг баталж 2015 оноос хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.

1.19 Дээрх журмын дагуу жил бүрийн эхэнд ТЗНШБ-д тавигдах шаардлагыг хорооны гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн баталж, тухайн жилийн эцэст тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлсэн нөхцөл шаардлагын биелэлтийн тайланд тусгай зөвшөөрлийн бодлого зохицуулалтын хэлтэс үнэлгээ өгөн ажиллаж байна.

1.20 ХХТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1.2¹⁵, ХХЗХ-ны дүрмийн 5.3.7¹⁶, Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журмын 2.7¹⁷, Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний чанарыг хянах журамд тус тус заасны дагуу ХХЗХ-ноос тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны чиглэлээр ерөнхий нөхцөл шаардлагуудыг хорооны хурлын тогтоолоор батлан, тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулсан гэрээнд тусгаж, зохицуулалтын алба, радио давтамжийн алба, зах зээл, үнэ тарифийн алба, шуудангийн алба, захиргааны албадууд хариуцсан чиглэлийн дагуу байнгын, төлөвлөгөөт болон өргөдөл гомдлын дагуу хяналтыг хэрэгжүүлж байна.

1.21 Ирсэн өргөдөл, гомдлыг тухай бүрд нь шийдвэрлэн ажиллаж, Засгийн газрын 1111 тусгай дугаарт болон ХХЗХ-нд ирсэн өргөдөл, гомдол 2015 онд өмнөх онтой харьцуулахад 49.1 хувиар буурсан байна.

1.22 2014-2015 онуудад радио давтамжийн хяналт, зохицуулалтын чиглэлээр орон нутагт төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, гэрээт төлөөлөгчдөд сургалт явуулан үүсч буй харилцан нөлөөллийн нөхцөл байдлыг арилгаж ажилласан байна.

1.23 Олон улсын жишгээр Харилцаа холбооны зохицуулах чиг үүрэг бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд улсын байцаагчийн эрхтэйгээр хяналт шалтгалт хийхээс илүүтэй хяналт зохицуулалтын үйлчилгээ үзүүлэх нь зохимжтой гэж үздэг боловч харилцаа холбооны чиглэлээр хяналт шалгалт хийх хүн хүч, техникийн хувьд хүрэлцээгүйтэй холбоотойгоор МХЕГ-аас 1 улсын байцаагч, ХХЗХ-ноос улсын байцаагчийн эрхтэй 2 инженер хяналт шалгалт хийж байна.

1.24 Энэ нь харилцаа холбооны тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд тавих бусад мэргэжлийн байгууллагын хяналт хангалтгүй байгааг илтгэж байна.

Хуульд заасан бичиг баримтын бүрдэл хангаагүй ААН-д тусгай зөвшөөрөл олгосон тохиолдол гарсан байна

1.25 Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “...хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авах тухай өргөдөлдөө... байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, тухайн хуулийн этгээдийн санхүү, хөрөнгийн нөөц, эдийн засгийн чадавхи, үйл ажиллагаагаа эхлэх хугацаа, хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэрийн талаарх бичиг баримтуудыг хавсаргана” гэж заасан байна.

1.26 Аудитын явцад 2014-2015 онд 68 ТЗЭ-д зөвшөөрөл олгосноос санамсаргүй түүврийн аргаар сонгон 36 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрөл хүссэн бичиг баримтын бүрдлийг шалгахад 25 хувьд нь доорх зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Хорооны хурлаар байгаль орчны үнэлгээ хийгдээгүй, ТЭЗҮ-ийн тоо баримт зөрүүтэй, санхүүгийн тайлан ирүүлээгүй зэрэг зөрчилтэй Дезерт Солар Пауэр Вуан ХХК, Энерго тех сервис ХХК, ЭДЦС ХХК-уудад тусгай зөвшөөрөл олгосон;
- Зээлийн эх үүсвэрээр барихаар тооцоолсон үйл ажиллагаанд санхүүгийн чадвар хангалтгүй Хөдөөгийн цахилгаан, Энерго сервис монтаж, Энерготех сервис, Энержи стар зэрэг 8 ААН-д тусгай зөвшөөрөл

¹⁵ Харилцаа холбооны талаар баримталж буй бодлогын хүрээнд хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, түүнийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавих, гэрээ байгуулах

¹⁶ тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, гэрээний биелэлтэд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллан тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг заавар, зөвлөмжөөр хангах;

¹⁷ Зохицуулах хорооны тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоож, тусгай зөвшөөрлийн гэрээнд үүрэг болгоно;

олгохоор хорооны хурлаас шийдвэрлэсэн боловч тухайн ААН-үүд санхүүгийн эх үүсвэргүй гэсэн шалтгаанаар
гэрчилгээ аваагүй;

1.27 Энэ нь ЭХЗХ-ны үйл ажиллагаанд тавигдах үе шатны дотоод болон хөндлөнгийн
хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Бүлэг 2 Зохицуулах хороод орлогын төвлөрүүлэлт, хөрөнгийн зарцуулалтын үр нөлөөг нэмэгдүүлэх талаар хангалтгүй ажиллаж байна

Зохицуулалтын үйлчилгээний хөлс тооцох аргачлалыг дахин боловсруулах, төлбөр хураамжийн давхардлыг арилгах шаардлагатай байна

2.1 ЭХЗХ нь Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6¹⁸-д заасны дагуу зохицуулалтын үйлчилгээний хөлс (ЗҮХ)-өөр санхүүжиж байна. Анх Дэд бүтцийн сайдын 2001 оны 334 дүгээр тушаалаар ЗҮХ-ийг цахилгаан, дулаан түгээх, дамжуулах, хангах төлөвлөсөн хэмжээг тухайн орлогыг тооцох дундаж тарифт харьцуулан тооцож байжээ.

2.2 Харин ЭХЗХ-ны 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Эрчим хүчний зохицуулалтын үйлчилгээний хөлс тооцох аргачлал”-ын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс “нэг удаагийн ЗҮХ”, “жил бүр авах ЗҮХ”-ийг нийт хэмжээ нь Хорооны тухайн жилийн төсөвт зардлыг хангаж байхаар төвлөрүүлэхээр заасан байна.

2.3 **Нэг удаагийн ЗҮХ нь** тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг хүлээн авах, танилцах, хянах хөлс 300.0 мянган төгрөг, гэрчилгээг гээгдүүлсэн, ашиглах боломжгүй болгосон тохиолдолд нөхөн олгох, солих, зөвшөөрлийн эзэмшигчийн хүсэлтээр шинэчлэх хөлс 100.0 мянган төгрөг, тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамааруулан суурилагдах хүчин чадал, хүчин чадлын нэгжийн хөлсний хэмжээтэй уялдуулан харилцан адилгүй байхаар тогтоосон байна. Зарим зөвшөөрлийн ЗҮХ нь суурь хураамж, хүчин чадалд харьцуулсан төлбөр гэсэн 2 хэсгээс бүрдэж байна.

2.4 Тухайлбал, Эрчим хүчний барилга, эх үүсвэр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөх тусгай зөвшөөрөл хүсэхэд төлөх суурь хөлс 25.0 сая төгрөг, үүн дээр суурилагдсан хүчин чадлыг 1МВт чадлын хөлс 50.0 мянган төгрөгөөр үржүүлэн нэмж төлөхөөр тогтоосон байна.

Хүснэгт 5. Эрчим хүчний барилга, байгууламж барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ (мянган төгрөг)

ТЗЭ-ийн нэр	Зөвшөөрлийн төрөл	Хүчинтэй хугацаа /жилээр/	Нэг удаагийн ЗҮХ		
			Суурь хураамж	Хүчин чадалд харьцуулсан хөлс	Үйлчилгээний нийт хөлс
“Эрэл” ХХК	Сэргээгдэх эх үүсвэр	3	25,000.0	1,400.0	26,140.0
"Мон Кореа Инженеринг" ХХК	Сэргээгдэх эх үүсвэр	3	25,000.0	400.0	25,400.0
"Соларповер интернейшнл" ХХК	Сэргээгдэх эх үүсвэр	3	25,000.0	500.0	25,500.0
"Дөргөний нарны цахилгаан станц" ХХК	Сэргээгдэх эх үүсвэр	3	25,000.0	500.0	25,500.0
"Ти Би Эф монголиан пауэр" ХХК	Сэргээгдэх эх үүсвэр	5	252,000.0		252,000.0
"Энержи плас" ХХК	Дулааны станц	2	25,000.0	1,750.0	26,750.0
"Клинтек" ХХК	Сэргээгдэх эх үүсвэр	3	25,000.0	12,500.0	27,500.0

*Эх сурвалж: Хорооны санхүүгийн албанаас гаргасан судалгаа

2.5 Дээрх аргачлалын дагуу 6 төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах ЗҮХ-ийг 0.5 сая төгрөгөөс 25.0 сая төгрөгийн, диспетчерийн зохицуулалт

¹⁸ Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон болон тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлсөөр санхүүжинэ.

хийх бол нэг удаагийн ЗҮХ-ийг 2.5 сая төгрөгийн суурь хураамжтай байхаар тус тус тогтоосон бөгөөд тооцоолол хийсэн үндэслэл, нотлох баримт дутмаг байна.

2.6 Эрчим хүчний барилга, байгууламж барих зөвшөөрлийн хүчинтэй хугацааг хуульд 5 хүртэл жилээр олгоно гэж заасан байна. Хороо зөвшөөрөл хүсэгч ААН-ийн санхүүгийн чадвар, төслийн үргэлжлэх хугацааг харгалзан 1-4 жилийн хугацаагаар олгож байгаа гэх боловч “Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах журам”-д энэ талаар тодорхой тусгаагүй, хорооны гишүүдийн хуралдаанаар зөвшөөрлийн хүчинтэй хугацааг тогтоож байгаа нь зөвшөөрөл олгох үйл явц нээлттэй бус байгааг харуулж байна.

2.7 **Жил бүр төлөх ЗҮХ**-ийг тусгай зөвшөөрөлд заасан төлөвлөсөн үйл ажиллагааны орлогын дүнг ЭХЗХ-ний тухайн жилийн төсвөөс тухайн жилд тооцсон нэг удаагийн ЗҮХ-ийг хассан дүнд ногдох коэффициентоор үржүүлэн тооцохоор заасан байна.

2.8 Дээрх аргачлалыг боловсруулахдаа ЭХЗХ-ноос ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг гадаадын 8 орны төлбөрийн жишиг үзүүлэлтэд судалгаа хийж (ЭХЗХ-ны судалгааны тайланд үндэслэв), хамгийн өндөр төлбөр, хураамжтай Гана, Нигери орнуудын жишгийг Монгол Улсад мөрдөхөөр сонгон авч ЗҮХ тооцох аргачлалд ашиглажээ.

2.9 ЗҮХ тооцох аргачлал нь зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийн хугацааг сунгуулахад анх хүсэлт гаргасантай адил материал хүлээн авах, танилцах, хянах хөлсийг дахин төлж, үйлчлүүлэгчийн хувьд илүү зардал гаргах нөхцөлийг бий болгож байна.

2.10 Мөн ЭХЗХ ашигтай ажиллаж байгаа нь дээрх аргачлалын 3.1.2-т заасан “Эрчим хүчний ЗҮХ-ний нийт хэмжээ нь Хорооны тухайн жилийн батлагдсан төсөвт зардлыг хангаж байх” гэсэн зарчимтай нийцэхгүй байх тул төлбөр хураамжийн хэмжээг бодит зардалд үндэслэн, хэрэглэгчдэд хүргэх эцсийн үнэ тарифт нөлөөлөхгүй байхаар аргачлалыг дахин боловсруулах шаардлагатайг харууллаа.

2.11 Тусгай зөвшөөрөл олгогдсон ААН улсын тэмдэгтийн хураамжийг Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн дансанд тушаах ёстой боловч хороо дүүргийн татварын хэлтэстэй тэмдэгтийн хураамжийн орлогын тулган баталгаажуулалт хийдэггүй, улсын төсөвт хураамжийн орлого төвлөрүүлсэн эсэхэд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2.12 Цаашид ЭХЗХ тэмдэгтийн хураамжийн төвлөрүүлэлтэд хяналт тавих, татварын хэлтэстэй тооцоо нийлж баталгаажуулах, ажлын уялдааг сайжруулах нь зүйтэй байна.

2.13 ХХЗХ нь ХХТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1.4¹⁹ болон 9 дүгээр зүйлийн 9.1.11²⁰, РДТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.2.3²¹-д заасны дагуу ЗҮХ-ний хэмжээ болон радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоосон байна.

2.14 Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоохдоо радио зурвас ашиглалт, хамрах хүрээ, төрөл ангиллыг тооцож тогтоосон бөгөөд үндсэн зарчим нь давтамжийн цар хүрээ, зурвасын өргөн, нэвтрүүлэгчийн чадал, төрөл ангилал гэсэн хувьсах хүчин зүйлүүдээс шалтгаалан төлбөрийн хэмжээ өөрчлөгдөж байхаар зохицуулагдсан байна.

¹⁹ Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журмыг батлах

²⁰ ХХЗХ нь бүрэн эрхийнхээ хүрээнд ХХТХуулийн 6.1.4-д заасан журмын дагуу зохицуулалтын үйлчилгээний хөлсний хувь хэмжээг тогтоох

²¹ Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн хүрээнд радио давтамжийн хуваарилалтын нэгдсэн бүртгэл гаргах, радио давтамжийн зурвасыг ашиглах, төлөвлөх, хуваарилах болон радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох журам батлах

2.15 Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх ЗҮХ-ний хэмжээ тогтоох ХХЗХ-ны 2011 оны 15 дугаар тогтоолын 3.2²²-д “төлбөрийн хэмжээг жил бүр өөрчлөн тогтоож болно” гэж заасан хэдий ч ЗҮХ-ний хэмжээ байнга өөрчлөгдөж байх нь хэрэглэгчдэд хүрэх үнэ тариф тогтворгүй болох нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэн хорооны зүгээс өөрчилдөггүй байна.

2.16 Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.33²³, 30 дугаар зүйлийн 30²⁴ -д заасны дагуу зөвшөөрөл олгоход тэмдэгтийн хураамжийг улсын төсөвт төлдөг бөгөөд 2014 онд 25.3 сая, 2015 онд 22.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ.

ЭХЗХ зарим зардлыг арвилан хэмнэлтгүй зарцуулж, хөрөнгийн зарцуулалтын үр нөлөө, үр ашгийг тооцдоггүй байна

2.17 ЭХЗХ-ны санхүүгийн тайланд 2014 оны нийт төсвийн 65.6 хувь буюу 1,417.3 сая төгрөгийг ажилтан, албан хаагчдын цалин, түүнтэй адилтгах зардал эзэлж байсан бол 2015 онд 68.4 хувь буюу 1,624.9 сая төгрөг болж өмнөх оноос 2.8 хувиар өсчээ.

2.18 Хороо нь салбарын ҮЭХ-той байгуулсан хамтын гэрээний үндсэн дээр сар бүр ажилтнуудын ажлын үр дүнгээс хамаарч 32.0-60.0 хувиар тооцож цалингийн нэмэгдэл олгохоор тогтоожээ. Мөн жилийн эцэст тухайн жилийн үр дүнгийн урамшууллыг нэмж олгодог байна.

2.19 Цалин хөлсний хэмжээ өндөр байгаа шалтгаан нь салбарын хэмжээнд мэргэжил боловсрол өндөр, туршлага сайтай мэргэжилтнийг цалин өндөр тогтоож ажиллуулах шаардлагатай, нөгөө талаар олон улсын жишигтэй харьцуулан тогтоосон гэх тайлбарыг Тусгай зөвшөөрлийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга, Хорооны нягтлан бодогч нар өгч байна.

2.20 2014-2015 онд гадаад, дотоод сургалтын зардал 2013 онтой харьцуулахад дунджаар 47 хувийн өсөлттэй байгаа нь дотоодын англи хэлний сургалтад нийт, гадаадын богино хугацааны сургалтад зарим ажилтнуудыг хамруулснаас шалтгаалсан байна.

2.21 ЭХЗХ мэдлэг боловсрол өндөр, туршлага сайтай ажилтнуудын цалин, хөдөлмөрийн хөлсний хэмжээ өндөр байх шаардлагатай гэх боловч хувь хүний мэдлэгт хамааралтай сургалтад зардал гаргаж хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулж байгаа тул цаашид зардлын зориулалт, үр ашгийг тооцож хянах нь зүйтэй байна.

2.22 Мөн шуудан холбоо, мэргэжлийн үйлчилгээ, гадаад дотоод томилолт, цэвэрлэгээ болон аж ахуйн зардал, маркетингийн зардал, конторын хангамжийн зардлууд 2013 онтой харьцуулахад 0.3-2.2 хувийн өсөлттэй гарсан нь хорооны үйл ажиллагаа өмнөх онуудаас өргөжсөн, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ТЗЭ-дийн тоо өссөн, нөхцөл шаардлагын биелэлтийг шалгах аар орон нутагт томилолтоор ажиллах шаардлага ихэссэн, холбогдох үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

2.23 Цаашид орон нутгаас хийгдэх хяналтыг хорооноос цалинждаг аймаг, нийслэлийн орон тооны зохицуулагчдаар дамжуулан хэрэгжүүлж дотоод томилолтын зардлаа хэмнэх боломжийг эрэлхийлж ажиллах шаардлагатай байна.

²² Жил бүрийн төгрөгийн ханшийн өөрчлөлттэй уялдуулан зохицуулан үйлчилгээний хөлсний хэмжээг өөрчлөн тогтоож болно.

²³ Харилцаа, холбооны тухай хуулийн 12.1-т заасан тусгай зөвшөөрөл олгох;

²⁴ Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

ХХЗХ нь тэтгэмж, урамшууллыг хавтгайруулан олгосноос хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бий болгож байна

2.24 ХХЗХ-ны орон тоо цалингийн жишгийг анх Дэд бүтцийн сайдын 2002 оны 237 дугаар тушаалаар баталжээ. Үүнээс хойш ХХЗХ-ны даргын тушаалаар 11 удаа цалинг шинэчлэн тогтоосон байна.

2.25 ХХЗХ нь гүйцэтгэлийн үнэлгээнд үндэслэн үр дүнгийн урамшууллыг улирлаар буюу жилд 4 удаа тооцож олгодог байна. Ингэхдээ “А”, “В” үнэлгээ авсан ажилтан өөрийн үндсэн цалинг 1.2 болон 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний үр дүнгийн урамшуулал авах нөхцөлтэй байгаа нь “Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам батлах тухай” Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 3²⁵-д заасантай харьцуулахад урамшууллын хувь хэмжээ өндөр, хавтгайруулан олгож байгаа нь тэр хэмжээгээр зардлын хэмнэлт гарахгүй байна.

2.26 Үр дүнгийн урамшуулал тооцож олгосон мэргэжилтний цалингийн хэмжээ дунджаар 2.1– 2.7 сая төгрөг байгаа бөгөөд урамшууллын зардалд 2014 онд 397.4 сая, 2015 онд 463.2 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

2.27 ХХЗХ-ноос баталсан “Нийгмийн асуудал шийдвэрлэх журам”-д дэмжлэг, буцалтгүй тусламжийг ямар шаардлага хангасан ажилтанд хэрхэн олгох талаар тодорхой зохицуулалт хийж өгөөгүй тул нэг хүн олон удаагийн давтамжтайгаар буцалтгүй тусламж, дэмжлэг авах боломжийг бий болгожээ.

2.28 Мөн ХХЗХ-нд 2015 оны эцсийн байдлаар идэвхитэй 3,000 гаруй зөвшөөрөлд хамаарах 4,125.4 сая төгрөгийн авлага²⁶ байна. Үүнд өмнөх онуудын хуримтлагдсан авлага, дараа онд ноогдох зарим төлбөр, тарифын өөрчлөлтийн зөрүү, зөвшөөрөл цуцалснаас бий болсон найдваргүй авлагууд багтсан байна.

²⁵ Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох бүх төрлийн нэмэгдлийн нийт хэмжээ нь төрийн захиргааны болон тусгай албаны албан хаагчийн хувьд түүний албан тушаалын сарын цалин, бүх төрлийн нэмэгдлийн дүнгийн, төрийн үйлчилгээний албаны албан хаагчийн хувьд түүний албан тушаалын сарын цалин, нэмэгдэл хөлсний дүнгийн тус тус 40 хувиас хэтрэхгүй байхаар тогтоосугай

²⁶ 5-н зөвшөөрөл эзэмшигчээс авах 100.0-500.0 сая төгрөгийн дүнтэй 2,046.6 сая төгрөгийн авлага байгаа нь нийт авлагын 49.6 хувийг эзэлж байна.

Дүгнэлт:

Эрчим хүч, харилцаа холбооны зохицуулах хороодын үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- ХХЗХ, ЭХЗХ-д төрийн чиг үүргийг хэрэгжүүлсний төлбөр, хураамжаар санхүүждэг боловч Хороодын үйл ажиллагааг нь зохицуулж буй хууль, журамд заагаагүйн улмаас улсын төсөвт орлого төвлөрүүлдэггүй байна.
- 2014-2015 онуудад хороодын үйл ажиллагаанд цахим системийг нэвтрүүлсэн, нэг цонхны үйлчилгээг бий болгосноор тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлж буй үйлчилгээнд ахиц гарсан байна.
- Хороод тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавьж байгаа ч мэргэжлийн байгууллагаас тавих хөндлөнгийн хяналт хангалтгүй байна.
- ЭХЗХ зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоохдоо бодит тооцоо, судалгаанд үндэслээгүй, дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй байна.
- Хороод үйл ажиллагаа явуулахдаа зарим зардлыг арвилан хэмнэлтгүй, үр ашгийг тооцохгүйгээр зарцуулж байна.

Зөвлөмж:

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат танаа:

- ХХЗХ-ны радио давтамж ашиглалтын төлбөр болон төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл, ЭХЗХ-ны үйл ажиллагааны ашгаас нормативт хэмжээгээр үлдээж үлдэх ашгийг улсын төсөвт төвлөрүүлэх боломжтой тул Хороодын үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

Эрчим хүч, Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга нарт:

- Зохицуулалтын үйлчилгээний хөлс тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулж, мөрдөх;
- Хороодын зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хөндлөнгийн болон дотоодын хяналтын тогтолцоог холбогдох хууль журмын дагуу бий болгон, мөрдөж ажиллах;
- Төлбөр хураамжийн орлогын төвлөрүүлэлт, түүний зарцуулалтыг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулахад анхаарч санхүүгийн дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх талаар тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Эрчим
хүчний
зохицуулах
хорооны
санал

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

14201 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 2а,
Утас: 32-01-26, Факс: (976-11) 31-93-35,
E-mail: info@erc.mn

2016.05.25 № 4/505
танай _____ -ны № _____ -т

Танай 2016 оны 4/912 тоотын хариу

2016 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 4/912 тоотоор Хуульд заасан хугацаанд албан бичгээр саналаа ирүүлээгүй байгаа тул Хорооны зүгээс аудитын тайлангийн төсөлд өгөх санал байхгүй гэж үзэн тайланг эцэслэхээр шийдвэрлэсэн утга бүхий албан бичгийг ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газраас “Эрчим хүчний тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн аудитын тайлангийн төслийг 2016 оны 5 дугаар сарын 17-ны өдөр манай байгууллага дээр ирж албан ёсоор танилцуулж хүлээлгэн өгсөн болно. Бид тайлангийн төсөлтэй танилцан 2016 оны 5 дугаар сарын 19-ны өдөр Хорооны хурлын зааланд Аудитын менежер Л.Эрдэнэчулуун, шинжээч Б.Мөнхтуяа нартай уг тайлангийн төсөлд зарчмын зөрүүтэй санал дүгнэлтийн талаар тайлбар тодруулга хийсэн бөгөөд тухайн өдөр шинжээч Б.Мөнхтуяагийн электрон шуудангаар саналаа нэгтгэж явуулсан.

Төрийн аудитын тухай хуулийн 19.3.1-д “Аудит хийлгэсэн байгууллагад тайлангийн төслийг өгч ажлын 10 хоногийн дотор саналаа өгөхийг хүсэх” гэж заасны дагуу ажлын 10 хоногт багтаан тайлангийн төсөлд өгөх саналыг хавсралтаар хүргүүлж байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА  Л.ЭРДЭНЭЧУЛУУН



Харилцаа,
холбооны
зохицуулах
хорооны санал



МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Монгол улс, Улаанбаатар 14201, Д.Сүхбаатарын
гудамж-13, Метро бизнес төв, 5 давхар,
Утас: 304257, 304258, факс: 327720

E-mail: info@crc.gov.mn Web site: www.crc.gov.mn

2016.05.13 № 01/892
ТЭГНИЙ 2016.05.05 -ны № 4/859 -Т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Танай газраас 2016 оны 05 дугаар сарын 05-ны
өдрийн 4/859 тоот албан бичгээр ирүүлсэн аудитын
тайлангийн төсөлд дурдсан дүгнэлтэд саналыг хүргүүлж
байна.



ДАРГА

Б.БАЛГАНСҮРЭН

0003279

ЭХЗХ-ны саналд өгсөн ҮАГ-ын тайлбар:

Тайланд дурдагдсан асуудлаар 24 тайлбар, санал ирүүлснээс 18 санал, тайлбарыг хүлээн авч, тайланд нэмэлт өөрчлөлт оруулсан. Нотлох баримтаар дэмжигдээгүй, тайлбар хэлбэрээр ирүүлсэн зарим хэсгийг тайланд хэвээр үлдээв.

ХХЗХ-ны санал өгсөн ҮАГ-ын тайлбар:

ХХЗХ-ноос тайланд дурдагдсан асуудлуудаар 3 тайлбар, санал ирүүлснийг үндэслэн тайлангийн холбогдох хэсэгт найруулгын өөрчлөлт хийж, агуулгыг хэвээр үлдээв.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2016 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/118

Улаанбаатар хот


Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23 дугаар зүйлийн 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүч, харилцаа холбооны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын нэгтгэсэн тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг УИХ-ын Төсвийн Байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, салбар тайланг Эрчим хүчний зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хороонд тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитын тайланд дурьдагдсан зөрчлүүдийг арилган, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2017 оны 3 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Эрчим хүч, Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга нарт зөвлөсүгэй.
4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор /М.Наранжаргал/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

А.ЗАНГАД



This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.